

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГААС 2021 ОНЫ 3 ДУГААР УЛИРАЛД БАТЛАН ГАРГАСАН ЗАХИРАМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

2021.10.06

Цагаандэлгэр сум

№	Захирам жийн дугаар	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Заалтын дугаар	Заалт	Хариуцан хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжилт, үр дүн	Хувь
1	A/27	Хуулийн хэрэгжилтийг хангуулах тухай 2021.01.18	3	Хоёр. Тус захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү төрийн сангийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Энхтайван), Мэргэжлийн хяналтын газрын дарга (Ш.Төрбат), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.	СТСХ МХГ Сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай	Төсөвт байгууллагын ажилчдын цалингийн зээл сарын сүүлээр төлөгддөг тул цалинг 2 хувааж авахаар сарын эцэст зээлээ төлж чадахгүй байна гэсэн албан хаагчдын саналын дагуу цалинг сард 1 удаа тооцож олгож байна. Цалингаа 2 хувааж авах боломжтой, авахыг хүссэн албан хаагчдад тухайн үед нь цалингийн урьдчилгаа байдлаар олгож байна. 2021 оны 3 дугаар улирлын байдлаар 6 төсөвт байгууллагын 25 /давхардсан тоогоор/ албан хаагчид 5,350.0 мянган төгрөгийн урьдчилгаа цалин олгосон байна.	100
2	A/56	Ажлын хэсэг байгуулах тухай 2021.02.15	6	Гурав. Энэ захирамж гарсантай холбогдуулан сумдын өнгө үзэмжийг сайжруулах, ашиглалтгүй байгаа барилга байгууламжийг цаашид ашиглах эсэх талаар шийдвэрлэж тодорхой арга хэмжээ авч ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Сумдын Засаг дарга нар	Сумын өнгө үзэмжийг сайжруулах, ашиглалтгүй байгаа барилга байгууламжийг засварлуулах шаардлага хангахгүй барилгыг буулгуулан хүлээж авах талаар ажлын хэсэг байгуулан “Сумын үзэмж-манай хашаанаас” 2 сарын аян зарлан эгнээ хариуцсан гишүүд айл өрх бүрт албан мэдэгдэл хүргэж, өрх бүр хашаа байшингийнхаа өнгө үзэмжийг сэргээсэн. ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 1 барилга, иргэдийн санаачлагаар 1 барилгыг засварласан.	70

3	A/93	Сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын 2020 оны үйл ажиллагааны үр дүнгийн тухай 2021.03.09	9	Хоёр. Аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанаас тэмдэглэлээр өгсөн нийтлэг хэрэгжүүлэх зөвлөмж, Хяналт - шинжилгээний үнэлгээний ажлын хэсгээс өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөн хэрэгжилт үр дүнг тооцон зөвлөмжийн хэрэгжилтийг 6, 11 сарын 25-ны дотор Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтэст тайлагнахыг сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга нарт үүрэг болгосугай.	Сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга нар	2020 оны сумын Засаг даргын Тамгын газар, харьяа төсвийн байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын хэсгээс өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2021.03.26-ны өдөр сум Засаг даргаар батлуулан хяналтандаа авч холбогдох байгууллага, албан хаагчдад хэрэгжилтийг зохион байгуулахад анхаарах асуудлуудын талаар чиглэл өгсөн. 2021.06.28-ны өдөр зөвлөмжийн хэрэгжилтийг тооцож гарган ХШҮДАХ-т хүргүүлсэн.	100
4	A/202	Аймгийн 2021-2024 оны Стратеги төлөвлөгөө батлах тухай 2021.03.24	28	2. Аймаг болон салбарын стратеги төлөвлөгөөнд нийцүүлэн Засаг даргын эрхлэх хүрээний агентлагууд тус бүр чиг үүргийн дагуу стратеги төлөвлөгөө боловсруулан батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулахад шаардагдах зардлыг жил бүрийн төсөвтөө тусган, явцын үр дүнг жил бүр тайлагнаж ажиллахыг төсвийн шууд захирагч, сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Төсвийн шууд захирагч, сумдын Засаг дарга нар	-	ҮБ

5	A/237	Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай 2021.06.24	1	1. Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын 2021 оны А/139 дугаар тушаалын дагуу 2021 оны 6 дугаар сарын 24-ний өдрөөс 7 дугаар сарын 01 хүртэлх хугацаанд Цагаандэлгэр сумын үхэр болон бог малыг гоц халдварт шүлхий өвчний дархлаажуулалтад бүрэн хамруулах, малчид, мал бүхий иргэдэд тов хүргэж, зарлан мэдээлэлж ажиллахыг Цагаандэлгэр сумын Засаг дарга нар (Д.Буджав) үүрэг болгосугай.	Цагаандэлгэр сумын Засаг дарга	Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын 2021 оны А/139 дугаар тушаалын дагуу тус суманд малын гоц халдварт Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг зохион байгуулж 179 өрхийн үхэр 3057, хонь 85949, ямаа 57671 нийт 146677 малыг хамруулсан байна.	100
6	A/246	Аймаг, сумдын баяр наадмыг зохион байгуулахгүй байх тухай 2021.07.07	9	2.Аймаг сумдын баяр наадамд зориулан төлөвлөсөн зардлыг Коронавируст халдвар (ковид-19)-ын хариу арга хэмжээний зардалд зарцуулах төслийг боловсруулан шийдвэрлүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргыг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргыг түр орлон гүйцэтгэгч Сумдын Засаг дарга нарт	Сумын баяр наадамд зориулахаар төлөвлөсөн 5,000.0 мянган төгрөгийн зардлыг Коронавируст халдвар (ковид-19)-ын хариу арга хэмжээний зардалд зориулахаар батлуулж сумын ЭМТ-д ПСР-ын болон түргэвчилсэн шинжилгээ, оношлогооны хэрэгсэл худалдан авч өгсөн.	100
7	A/277	Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх хяналт тавьж ажиллах тухай 2021.08.08	10	2.Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчин гарсан хөрш зэргэлдээ аймаг, сумдаас малын худалдаа, шилжилт хөдөлгөөн, мал тээвэрлэлт хийх үйл ажиллагаа болон мал, амьтны гаралтай түүхий эд, мах махан бүтээгдэхүүнд тавих хяналт шалгалтыг чангатгаж, малын гарал үүслийн гэрчилгээ, мал эмнэлэг, ариун цэвэр, хорио цээрийн дэглэмийг чанд мөрдүүлж ажиллахыг Мал эмнэлгийн газар, Хүнс, Хөдөө аж ахуйн газар, Цагдаагийн газар, Мэргэжлийн	Мал эмнэлгийн газар ХХААГ ЦГ МХГ Сумдын Засаг дарга нарт	Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчин гарсантай холбогдуулан голомтын бүс орчимд Өндөр сүүж гэх газар хяналтын постыг 24 цагаар ажиллуулж хяналт тавин ажиллаж хөрш зэргэлдээ аймаг, сумдаас малын шилжилт хөдөлгөөн, мал тээвэрлэлт хийх үйл ажиллагаа хийгдээгүй.	100

				хяналтын газар, сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.			
			11	3.Гадны аймгуудад отор нүүдлээр нүүдэллэж байгаад орон нутагтаа ирж буй малын шилжилт хөдөлгөөн ихсэж байгаатай холбогдуулан гоц халдварт болон халдварт өвчтэй бүс нутгаас эрүүл бүс рүү мал орж ирэхээс урьдчилан сэргийлэх, малд эрүүл мэндийн үзлэг хийж, мал эмнэлэг, ариун цэврийн гарал үүслийн гэрчилгээг шалгаж орон нутагт нь нэвтрүүлэх, өвчний сэжигтэй бүс нутгаас мал оруулахгүй байхыг Хүнс, Хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлгийн газар, Цагдаагийн газар, сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.	Мал эмнэлгийн газар ХХААГ ЦГ МХГ Сумдын Засаг дарга нарт	Отор нүүдэл хийж байгаа гадны сумын 4 өрхийн үхэр 83, хонь 2095, ямаа 1979 малд малд үзлэг хийж урьдчилан сэргийлэх дархлаажуулалтанд хамруулсан.	100
			12	4.Өөрийн сумын малчдад шүлхий өвчний талаар урьдчилан сэргийлэх мэдээлэл хүргэж, малд тандалт судалгаа, эрүүл мэндийн үзлэг хийж өвчний сэжиг илэрсэн үед баталгаажих хүртэл өвчний халдварыг голомтод хязгаарлалт, хорио цээрийн дэглэм тогтоох, өвчтэй малыг ялган тусгаарлах, устгах, булшлах, халдваргүйжүүлэх зэрэг арга хэмжээг холбогдох хууль, дүрэм, зааврын дагуу шуурхай авч хэрэгжүүлэхийг сумдын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт даалгасугай.	Сумдын Засаг дарга нарт Онцгой комиссын дарга нарт	2021 оны 8-р сарын 13-нд Хараат багийн нутаг Дөрвөлж гэдэг газар отроор нутаглаж байсан Говь-Угтаал сумын малчин Ж.Мөнх-Оргилын суурьт малын гоц халдварт Шүлхий өвчин гарч хорио цээрийн дэглэм тогтоож 8-р сарын 15-18-ны өдрийн хооронд голомтын бүсэд байгаа отор нүүдлийн 4 өрхийн үхэр 83, хонь 2095, ямаа 1979 малыг вакцинд хамруулсан. 9-р сарын 23-ны өдрийг хүртэл хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоож, хяналтын пост ажиллуулсан.	100
8	A/249	Мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах,	15	2. Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж, мал, амьтны шилжилт хөдөлгөөнд тавих хяналтыг сайжруулж, отор нүүдэл,	Мал эмнэлгийн газар	Отор нүүдэл хийж байгаа гадны сумын 4 өрхийн үхэр 83, хонь 2095, ямаа 1979 малд малд үзлэг хийж урьдчилан сэргийлэх дархлаажуулалтанд хамруулсан.	100

		хяналт тавих тухай		шилжилт хөдөлгөөнөөр ирсэн сүрэгт үзлэг хийж, сумын мал эмнэлгийн тасаг, нэгжийн эмчийг мэргэжил арга зүйн зөвлөгөө, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Мал эмнэлгийн газар (Ш.Мөнхдүүрэн), Сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Сумдын Засаг дарга нарт		
			16	3. Мал амьтны гоц халдварт өвчингүй тайван бүс нутгаас ирсэн мал, амьтныг нэвтрүүлэхдээ мал эмнэлгийн цахим гэрчилгээтэй, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт болон шимэгчлэх өвчнөөс эмчлэх сэргийлэх арга хэмжээнд хамрагдсан сүрэгт үзлэг хийж, /адуунд нийлүүлэг, ям/ бусад малд шүлхий болон бог малын мялзан, бруцеллэзын шинжилгээний бичигтэй тохиолдолд нэвтрүүлэхийг Мал эмнэлгийн газар, Сумдын Засаг дарга, мал эмнэлгийн тасгийн байцаагч нарт үүрэг болгосугай	Мал эмнэлгийн газар Сумдын Засаг дарга нарт	Мал амьтны гоц халдварт өвчин гараагүй бүс нутгаас ирсэн малчдын малыг мал эмнэлгийн цахим гэрчилгээтэй, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт болон шимэгчлэх өвчнөөс эмчлэх сэргийлэх арга хэмжээнд хамрагдсан эсэхийг шалгаж мал сүрэгт үзлэг хийж ажилласан. Отор нүүдэл хийж байгаа гадны сумын 4 өрхийн үхэр 83, хонь 2095, ямаа 1979 малд малд үзлэг хийж, урьдчилан сэргийлэх дархлаажуулалтанд хамруулсан.	100
9	A/293	Хөдөө аж ахуйн салбар болон төв,суурин газрын 2021-2022 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах ажлын хэсэг байгуулах тухай 2021.08.20	31	2. Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг 2021 оны 10 дугаар сарын 15-ны дотор хангаж, тайлан мэдээг 10 дугаар сарын 20-ны дотор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт ирүүлэх, төв суурин газрын бэлтгэл ажлыг 2021 оны 09 дүгээр сарын 25-ний дотор хангаж, тайланг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст ирүүлэхийг сумдын Засаг дарга, харьяа газар, хэлтэс,	ХОХБТХ Сумдын Засаг дарга	Засгийн газрын 2021 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн 221 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын дагуу болзошгүй гамшгийн үед хэрэглэх өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэх, хадгалах хашаа, саравч, агуулахын бүрэн бүтэн байдлыг хангах арга хэмжээ авч, аюулгүй нөөцөд 84 тн өвс, 11,6 тн тэжээлийн нөөц бүрдүүлэн ажиллалаа. Багийн засаг дарга нараар өвөлжилт хаваржилтын бэлтгэл хангах талаар албан даалгаварыг бүх малчдад хүргүүлэн бэлтгэл ажил хангасан судалгааг авч нэгтгэн ХХААГ-т хугацаанд нь хүргүүлсэн. Малчин өрх бүрийг 4 тн-оос доошгүй гар тэжээл бэлтгүүлэх, хадлан тэжээл бэлтгэх талаар үүрэг	100

				албадын дарга нарт үүрэг болгосугай.		өгч сумын Засаг даргын албан даалгаврын дагуу малчид 194 тн өвс, 5 тн ногоон тэжээл, 75 тн үйлдвэрийн тэжээл, 221 тн гар тэжээл, 63 тн хужир шүү бэлтгэсэн мэдээг хүлээн авч нэгтгэн ХХААГазар мэдээг хүргэсэн. Төв суурин газрын өвөлжилтийн бэлтгэл хангах төлөвлөгөөний дагуу ААНБ-ын удирдлагуудад бэлтгэл, бэлэн байдлаа хангаж ажиллах чиглэл өгч ажиллалаа. 2021.10.01-ний өдрөөс халаалт эхлэхтэй холбогдуулан айл өрх, албан байгууллагуудыг сантехникийн бүрэн бүтэн байдлаа шалгахыг мэдэгдэж халаалтын байдал жигдэрсэн байна. Ган-Илч ХХК-ны уурын зуух эхний байдлаар 120 тн нүүрсийг татан авсан байна.	
10	A/295	Гоц халдварт шүлхий, бог малын мялзан өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг чангатгаж өндөржүүлсэн бэлэн байдалд шилжүүлэх тухай 2021.08.25	32	2.Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан шүлхий, бог малын мялзан өвчний халдвараас урьдчилан сэргийлэх, тэмцэх, халдваргүйтгэх, дархлаажуулах, хорио цээрийн дэглэмийг хатуу мөрдөж дараах үйл ажиллагааг 2021 оны 10 дугаар сарын 1-ны өдөр хүртэл зохион байгуулахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Сумдын Засаг дарга нар	2021 оны 8-р сарын 13-нд Хараат багийн нутаг Дөрвөлж гэдэг газар отроор нутаглаж байсан Говь-Угтаал сумын малчин Ж.Мөнх-Оргилын суурьт малын гоц халдварт Шүлхий өвчин гарч хорио цээрийн дэглэм тогтоож 8-р сарын 15-18-ны өдрийн хооронд голомтын бүсэд байгаа отор нүүдлийн 4 өрхийн үхэр 83, хонь 2095, ямаа 1979 малыг вакцин хамруулсан. 9-р сарын 23-ны өдрийг хүртэл хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоож, хяналтын пост ажилласан.	100

11	A/323	Зохион байгуулалтын арга хэмжээ авах тухай 2021.08.31	39	3.Өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийг сунгасан хугацаанд 15 суманд ажиллаж буй шалган нэвтрүүлэх хяналтын цэгүүдээр нэвтэрч байгаа автомашин, иргэдэд тавих хяналт, шалгалтыг эрчимжүүлж ажиллахыг Онцгой байдлын газар (М.Адъяабаатар), Цагдаагийн газар (Б.Мөнхбат), Эрүүл мэндийн газар (Б.Алтантөгс), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.	ОБГ ЦГ ЭМГ Сумдын Засаг дарга нарт	Шалган нэвтрүүлэх хяналтын 2 цэгийг Говьсүмбэр аймгийн төв зам, Улаанбаатар хотын төв зам дагуу байгуулан 24 цагаар нэг ээлжинд 4 алба хаагч буюу нийт 20 албан хаагчдыг ажиллуулан орох гарах хөдөлгөөнд хяналт тавин ажилласан. Энэ хугацаанд нийт орсон тээврийн хэрэгсэл 232, иргэн 476, гарсан тээврийн хэрэгсэл 172, иргэн 384 шалган нэвтрүүлэх цэгээр орох гарсан байна. Хяналтын цэгээр нэвтэрч буй иргэдийн шинжилгээний бичгийг шалгаж нэвтрүүлэх, мөн шинжилгээний бичиггүй иргэдээс түргэвчилсэн оношлуураар шинжилгээг авч сөрөг гарсан иргэдийг нэвтрүүлэн ажилласан. Мөн дамжин өнгөрч буй тээврийн хэрэгслийг сумын төвөөр оруулахгүй байхаар зохицуулж ажилласан.	100
12	A/364	Эмчилгээний ор дэлгэн ажиллуулах тухай 2021.09.29	49	3. Захирамжийн хэрэгжилтийг хангуулж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (А.Нарантуяа), халдвар хамгааллын дэглэмийг хангуулж хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), эмнэлгийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангаж ажиллахыг Цагдаагийн газар (Г.Наранбаатар), сумдын Онцгой комиссын дарга нарт тус тус үүрэг болгосугай.	НБХ МХГ ЦГ Онцгой комиссын дарга нарт	2021.09.14-ний өдрийн сумын Онцгой комиссын 20 дугаар хуралдаанаар Ковид-19 халдварын нөхцөл байдал хүндэрч тархалт нэмэгдэж байгаатай холбогдуулан ЭМТ-ийг соёлын төв рүү нүүлгэж, ЭМТ-ийн байранд нэмж ор дэлгэх талаар хэлэлцэж 16 ор нэмж дэлгэхээр шийдвэрлэсэн. Сумын Засаг даргын А/91 дүгээр захирамжаар ор дэлгэж ажиллуулах тухай шийдвэрийг гаргаж тусгаарлан эмчлэх эмнэлэгт 14 ор дэлгэн ажиллуулж байсан ба нэмж 16 ор дэлгэж нийт 30 орыг сумын хэмжээнд дэлгэн ажиллаж байна.	100
100 хувь-13, 70 хувь-1, 30 хувь-0, 0 хувь-0, ҮБ-1, ХБ-0							97,8

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР